



**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ,  
ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**

Грата Интернэшнл Монголиа

<https://gratanet.com/regions/mongolia>

## **ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ**

### **I. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

Чөлөөт бүсийн тухай хууль нь чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, гааль, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

“Чөлөөт бүс” гэдэгт гаалийн татвар болон бусад татварын хувьд гаалийн нутаг дэвсгэрийн гадна оршиж байгаад тооцогдох, аж ахуйн үйл ажиллагааны тусгай дэглэм бүхий Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэсгийг ойлгох ба чөлөөт бүс байгуулах зорилго нь тухайн бүсэд эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр иргэн, аж ахуйн нэгжийн экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, худалдаа, үйлчилгээний шинэ салбар, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх юм. Монгол Улсад одоогийн байдлаар Цагааннуур, Алтанбулаг болон Замын-Үүд боомтууд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд УИХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор Хөшигтийн Хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг Төв аймгийн Сэргэлэн суманд байгуулжээ.

#### ***Чөлөөт бүс байгуулах, өөрчлөх болон татан буулгах***

Монгол Улсад чөлөөт бүс байгуулах, түүний байршил, чөлөөт бүсэд олгох газар нутгийн хэмжээ, хилийн цэсийг тогтоох, өөрчлөх, татан буулгах, үйл ажиллагааны чиглэл, төрлийг тогтоох асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Чөлөөт бүсийг хилийн зурвас дахь газарт болон Засгийн газрын санал болгосон бүс нутагт байгуулна.

Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил залгаа улстай эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэл, тэдгээрийг хил дамнасан байгууламжаар холбох асуудлыг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулагдана.

Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хил залгаа улстай эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулж болох бөгөөд уг чөлөөт бүсэд баримтлах бодлого, чиглэл, тэдгээрийг хил дамнасан байгууламжаар холбох асуудлыг холбогдох улстай байгуулсан гэрээгээр зохицуулна. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн үйл ажиллагааг нээх, түр хаах асуудлыг Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар шийдвэрлэхээс гадна хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл бий болсон тохиолдолд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

### **II. ЧӨЛӨӨТ БҮСИЙН УДИРДЛАГА**

### Чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн

- чөлөөт бүсийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах;
- чөлөөт бүс байгуулах, өөрчлөх, татан буулгах талаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах;
- чөлөөт бүсийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах;
- чөлөөт бүс дэх төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
- чөлөөт бүсийн хөгжлийн төсөл болон чөлөөт бүсийн талаар Улсын Их Хурал, Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
- чөлөөт бүсийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг батлах;
- Хөрөнгө оруулагчдын зөвлөлөөс санал болгосон төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулахад тавих шалгуур үзүүлэлтийг тогтоох; болон
- хуульд заасан бусад

### Чөлөөт бүсийн захирагч

- чөлөөт бүсийн захирагч эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргах бөгөөд уг захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол өөрөө, эсхүл чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөх буюу хүчингүй болгоно;
- чөлөөт бүсийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар чөлөөт бүсийг төлөөлөх, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэр гаргах;
- чөлөөт бүсийн хөгжлийн хөтөлбөр, төсвийн төслийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах;
- чөлөөт бүсийн нэрийн өмнөөс гэрээ, хэлцэл хийх;
- чөлөөт бүсийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалтыг хариуцах, хяналт тавих;
- чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;
- чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах зөвшөөрөл олгох;
- чөлөөт бүсэд гарал үүсэл нь тодорхой, барааны тэмдэг, зураасан кодтой барааг худалдах талаар аж ахуй эрхлэгчид шаардлага тавих;
- чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт нийгмийн хэв журмыг сахиулах, галын аюулаас хамгаалах, яаралтай тусламж үзүүлэх зэрэг үйлчилгээг зохицуулж хэрэгжүүлэх;
- чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, тамхи худалдах зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу экспортлох зорилгоор уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газрын баталсан журмын дагуу олгох.

## III. ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ДЭГЛЭМ

Чөлөөт бүсэд гаалийн, визийн, Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн зорчих, хуулийн этгээдийн бүртгэлийн, валют зохицуулалтын, хяналтын, хөдөлмөр эрхлэлтийн, татварын болон бусад тусгай дэглэм үйлчилнэ.

### Гаалийн бүрдүүлэлт

*Барааг чөлөөт бүсэд оруулахад дараах баримт бичгийг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ:*

- хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах бараанд ачааны манифест, тээврийн баримт

<https://gratanet.com/regions/mongolia>

- бичиг, шаардлагатай тохиолдолд холбогдох зөвшөөрөл;
- Монгол Улсын нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулах бараанд дээрх баримт бичгээс гадна татвар төлсөн баримт.

### **Гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт**

*Дараах тохиолдолд гаалийн хялбарчилсан бүрдүүлэлт хийнэ:*

- Зорчигчийн хувийн хувийн хэрэглээний эд зүйлсээс гадна зорчигчийн худалдан авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад;
- Барааг хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад;

Хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах, чөлөөт бүсээс хилийн чанадад гаргах бараанд тарифын бус хязгаарлалт тогтоохгүй. Чөлөөт бүсэд нэвтрүүлж байгаа бараанд эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг тавина.

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь гаалийн байгууллагатай цахим мэдээллийн сүлжээнд холбогдсон байх бөгөөд чөлөөт бүсэд нэвтрүүлсэн барааны бүртгэлийг цахим хэлбэрээр хөтөлнө.

### **Чөлөөт бүс дэх визийн тусгай дэглэм**

Хилийн зурваст байрлалтай чөлөөт бүсэд хил залгаа улсын иргэн 30 хоногийн хугацаагаар визгүй, гуравдагч улсын иргэн харилцан зорчих нөхцөлийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зорчино. Уг визгүй зорчих хугацааг нэг удаад 30 хүртэл хоногоор сунгаж болно.

Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй болон "орох-гарах" визтэй гадаадын иргэн оршин суух болон визийн байх хугацаанд аль ч чөлөөт бүсэд визгүй зорчино.

### **Чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэл**

*Чөлөөт бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд дараах баримт бичгийг бүрдүүлэн бүртгүүлнэ:*

- Монгол Улсын хуулийн этгээд бол өргөдөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, бүртгэлийн хураамж төлсөн баримт;
- Гадаад улсын хуулийн этгээд бол өргөдөл, гадаад улсын хуулийн этгээдийг гэрчилсэн баримт бичгийн хуулбар, итгэмжлэл, бүртгэлийн хураамж төлсөн баримт.

Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дээрх баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянаж, холбогдох журамд заасан шаардлага хангасан гэж үзвэл чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох ба уг гэрчилгээ нь зөвхөн тухайн чөлөөт бүсэд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Чөлөөт бүсийн захирагчийн ажлын албанд бүртгүүлсэн хуулийн этгээд нь бусад хуулийн этгээдтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллаж болох бөгөөд чөлөөт бүсэд гэрээгээр

хамтран ажиллах хуулийн этгээд энэ хуульд заасны дагуу бүртгүүлж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ авах шаардлагатай.

*Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг дараах үндэслэлээр чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:*

1. хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй;
2. үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон;
3. татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан.

### **Чөлөөт бүс дэх хяналтын зохицуулалт**

Хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийнэ:

- гаалийн хяналтын явцад мал, амьтан, ургамал, хорио цээртэй холбоотой зайлшгүй шалгах шаардлага гарсан;
- чөлөөт бүс доторх бараа бүтээгдэхүүн, хүнсний эрүүл ахуй, барилга байгууламжийн чанар, байгаль орчны бохирдолтой холбоотой гомдол ирсэн.

### **Чөлөөт бүс дэх татварын тусгай дэглэм**

*Чөлөөт бүсэд татварын дараах хөнгөлөлт, чөлөөлөлт үйлчилнэ:*

1. хилийн чанадаас чөлөөт бүсэд импортолсон бараанд импортын гаалийн, нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татвар ногдуулахгүй;
2. импортын гаалийн, онцгой болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлж гаалийн нутаг дэвсгэрт оруулсан барааг чөлөөт бүсэд оруулахад татвар ногдуулахгүй бөгөөд гаалийн нутаг дэвсгэрт тухайн татварыг төлсөн баримтыг үндэслэн бусад татвараас хасалт хийж буцаан олгох;
3. монголын барааг гаалийн нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулахад нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хувь хэмжээгээр ногдуулах;
4. Зорчигчийн хувийн хувийн хэрэглээний эд зүйлсээс гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх;
5. Зорчигчийн хувийн хувийн хэрэглээний эд зүйлсээс гадна зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй бараанаас бусад барааг чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад гаалийн болон бусад татварыг холбогдох хуулийн дагуу ногдуулах;
6. барааг чөлөөт бүсээс хилийн чанадад гаргахад татвар ногдуулахгүй;
7. чөлөөт бүсэд бүртгэлтэй иргэн, хуулийн этгээдийн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй.
8. чөлөөт бүсэд баригдаж бүртгэгдсэн барилга байгууламжийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас бүрэн чөлөөлөх.

Засгийн газар 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааны нэр төрлийн жагсаалтыг тухай бүр баталж болох ба үүнд онцгой албан татвар ногдох бараа, эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн хамаарахгүй.

Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэн нь чөлөөт бүсийн захирагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө дампуурснаас бусад шалтгаанаар татан буугдсан буюу чөлөөт бүс дэх үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд хөнгөлж, чөлөөлсөн татварын хувь хэмжээний нийлбэрээр тухайн аж ахуйн нэгжийн татварын өрөнд шилжүүлэн тооцно.

#### **IV. ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Чөлөөт бүсэд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, олон улсын банк, санхүү, төлбөрт таавар, бооцоот тоглоом зэрэг бүх төрлийн үйл ажиллагаа явуулж болно. Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу зохицуулна.

##### ***Чөлөөт бүсийн аж ахуйн үйл ажиллагааны орлого***

*Чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба дараах орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ:*

- чөлөөт бүс дэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэний орлогын албан татвар, тэдгээрээс авах хураамж;
- чөлөөт бүсийн төрийн өмчийн барилга байгууламжийг эзэмшиж, ашигласны болон үйлчилгээ үзүүлсний төлбөр;
- газрын төлбөр;
- бусад аж ахуйн ажил, үйлчилгээний орлого.

Дээр заасан орлогын 20 хүртэл хувийг чөлөөт бүсийг хөгжүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг түргэтгэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор зарцуулдаг.

##### ***Хөрөнгө оруулагчдын зөвлөл***

Чөлөөт бүс нь хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, чөлөөт бүсийн хөгжлийг дэмжих, сурталчлах зорилго бүхий хөрөнгө оруулагчдын төлөөлөгчдөөс бүрдсэн Хөрөнгө оруулагчдын зөвлөлтэй байна. Хөрөнгө оруулагчдын зөвлөл нь хурлаараа баталсан дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулна.

Хөрөнгө оруулагч нь чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр чөлөөт бүсийн менежментийг хэрэгжүүлж болно.

#### **V. ЧӨЛӨӨТ БҮС ДЭХ ГАЗРЫН ХАРИЛЦАА**

Чөлөөт бүсийн газар нь боомтын газар нутагт хамаарахгүй. Чөлөөт бүс доторх газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах шийдвэрийг чөлөөт бүсийн захирагч гаргаж, түүний ажлын алба газар ашиглагчтай гэрээ байгуулах бөгөөд уг шийдвэрт

ашиглах газрын хэмжээ, хугацааг тусгасан байна. Чөлөөт бүсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах газрын суурь үнэлгээ болон газрын төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно.

Газар ашиглах эрхийг төсөл сонгон шалгаруулах, дуудлага худалдааны аль нэг хэлбэрийг ашиглан олгоно. Чөлөөт бүсэд газар ашиглуулах эрхийг төсөл сонгон шалгаруулалтаар авсан хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу итгэлцүүрээр тогтоосон дуудлага худалдааны анхны үнэтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөрөө төлсний дараа газар ашиглуулах эрхийн гэрчилгээ олгоно.

Чөлөөт бүсэд газар ашиглуулахтай холбогдсон бусад харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.

### ***Газрын төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт***

Худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар хөнгөлнө.

Чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгж, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс чөлөөт бүсэд ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар чөлөөлнө.

Чөлөөт бүсэд газар ашиглах гэрээ байгуулсан Монгол Улсын болон гадаадын хуулийн этгээд, иргэн газрын үр өгөөжийг ашиглах, хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа байдлыг нь харгалзан тэдгээрийг газрын төлбөрөөс тодорхой хугацаагаар хөнгөлж болно.

## **VI. ЧӨЛӨӨТ БҮСИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ**

Хилийн зурвас дахь чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг хил хамгаалах байгууллага, бусад чөлөөт бүсийн харуул хамгаалалтын үүргийг холбогдох байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр тус тус гүйцэтгэнэ. Чөлөөт бүсэд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг цагдаа, дотоодын цэрэг гүйцэтгэнэ.

### **Эх сурвалж:**

1. Гаалийн бүрдүүлэлтийг нэг мөр болгох тухай конвенц (1973)
2. Монгол Улсын Чөлөөт Бүсийн тухай хууль (2015)
3. Монгол Улсын Гаалийн Тариф, Гаалийн Татварын тухай хууль (2008)

4. Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам (2019)

**Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Грата Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн [bvolodya@gratanet.com](mailto:bvolodya@gratanet.com) болон Хуульч Б.Норовсүрэнгийн [nbayarsaikhan@gratanet.com](mailto:nbayarsaikhan@gratanet.com) хаягаар эсвэл +976 70155031 утсаар холбоо барина уу.**

*Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм Грата Интернэшнлийн Монгол дах оффис болох Өмгөөллийн "Грата Интернэшнл Монголиа" ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэв. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Иймд уншигч нь ямар нэгэн үйлдэл хийх/эс хийхээс өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.*